

## **Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журам**

### **НЭГ. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү журмын зорилго нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 10.1.7 дахь, 10.1.11 дэх, 35.4 дэх хэсэгт заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын шаардлага, орд ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлд нийцүүлэн уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авахад оршино.

1.2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд уурхай, уулын үйлдвэрийн ашиглалтын өмнөх бэлтгэл ажлыг бүрэн хангасны дараа Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргаж уурхайг хүлээн авах комисс (цаашид комисс гэх) томилуулах, томилогдсон комисс уулын болон баяжуулах үйлдвэрт ажиллахад энэ энэхүү журмыг мөрдөнө.

### **ХОЁР. Комиссын зохион байгуулалт, бүрэлдэхүүн**

2.1. Комиссыг дараахь байдлаар зохион байгуулна. Үүнд:

2.1.1. Стратегийн ач холбогдол бүхий ордыг түшиглэн барьж байгуулах уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг Засгийн газраас томилсон комисс хүлээн авч болно.

2.1.2. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс хүлээн авна.

2.2. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хэрхэн хангасан талаар хуулийн этгээд комисст танилцуулсны дараа бэлтгэл ажлын явцтай танилцах эсэхийг төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

2.3. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхлүүлэх, байнгын ашиглалтад хүлээн авах бэлтгэл ажил хангагдсан байдлыг хэлэлцэн хурлын тэмдэглэл хөтлөн зөвлөмж, албан даалгавар, акт үйлдэж бүх гишүүдийн гарын үсгээр баталгаажуулна.

2.4. Комиссын бүх гишүүдийн мэргэжлийн чиглэлээр санал, дүгнэлт бүхий гарын үсэг зурж баталгаажсан акт нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх, байнгын ашиглалтад хүлээн авсан эрх зүйн баримт бичиг болно.

2.5. Үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажлаа хангасан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах комиссын бүрэлдэхүүн 5-11 гишүүнтэй байх ба

ажил үүрэг, чиглэлийн дагуу холбогдох дараах яам, агентлагийн төлөөллийг оролцуулна. Үүнд:

- 2.5.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- 2.5.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- 2.5.3. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
- 2.5.4. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
- 2.5.5. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

2.6. Үйл ажиллагаагаа эхлүүлэх бэлтгэл ажлаа хангасан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн онцлогийг харгалзан тухайн комиссын бүрэлдэхүүнд шаардлагатай тохиолдолд дараах байгууллагуудын төлөөллийг оролцуулж болно. Үүнд:

- 2.6.1. Орон нутгийн төлөөлөл аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар
- 2.6.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага /Уул уурхайн аврах алба/

### **Гурав. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах комиссын анхаарах зүйлс**

3.1. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг”-т заасан баримт бичгийн бүрдэл хангасан эсэх;

3.2. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн талбай, хэсэг, цех, шат дамжлагын барилга байгууламж, тусгай зөвшөөрлийн талбайн шав тэмдэгт газар дээр нь хяналт хийж Техник, эдийн засгийн үндэслэл болон бусад зураг төслийн дагуу байгуулсан байдал, төсөлд тусгагдсан техник, технологи, тоног төхөөрөмж, машин механизмууд бүрэн ашиглагдаж байгаа эсэх;

3.3. Ажилтнуудын ажлын байр, ажиллах нөхцөл, ахуйн байр, технологийн болон унд ахуйн усан хангамж, цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэр, галын аюулгүй байдал, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, харилцаа холбооны систем нь аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм, журмын шаардлагад нийцэж буй эсэх;

3.4. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа нь “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Хүдрийн болон хүдрийн бус шороон ордыг далд аргаар ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм”, “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, уурхай, уулын үйлдвэрийн онцлог, технологи, шат дамжлагад холбогдох бусад хууль, дүрэм, журмын шаардлагад нийцэж байгаа эсэх;

3.5. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах, тэсэлгээний өмнөх бэлтгэл ажлын байрыг “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д зааснаар тоногдсон болон тэсэлгээний ажлыг энэхүү дүрмийн дагуу явуулж байгаа, явуулахаар төлөвлөж зохион байгуулсан эсэх;

## **ДӨРӨВ. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх хуулийн этгээдийн эрх, үүрэг**

4.1. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т заасны дагуу уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх улсын комисс ажиллуулах хүсэлт гаргахдаа хуулийн этгээд нь уурхай болон барилга, байгууламжийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсний дараа Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хүргүүлэх ба дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргасан байна.

4.2. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх хуулийн этгээд нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдлыг бүрэн хангаж комиссыг ажиллах боломжоор бүрэн хангана.

4.3. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламжийг холбогдох мэргэжлийн байгууллагын техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.

4.4. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг”-т заасан баримт бичгийн бүрдэл болон бусад холбогдох эрхзүйн баримт бичиг /2-р хавсралтад заасан/ -ийг бүрдүүлсэн байна.

4.5. Хуулийн этгээд нь баяжуулах үйлдвэрийн металл авалт, хаягдлын сангийн хоргүйжүүлэлт, далд уурхайн агааржуулалт, агаарын бохирдолт зэргийг хэмжиж мэргэжлийн байгууллагаар хянуулсан акт, баримт бүрдүүлсэн байна.

4.6. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах комиссын томилолтын зардлыг тухайн аж ахуйн нэгж хариуцана.

## **ТАВ. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг түр ба бүр хаах**

5.1. Ашигт малтмалын тухай хуулийн 45 дугаар зүйлийн дагуу уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хаах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## **ЗУРГАА. Бусад**

6.1. Уурхайг хүлээн авахтай холбоотой гарах маргаантай асуудлаар талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэр дээр байх ёстой  
бичиг баримтын жагсаалт

1. Хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар
2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн баримт
4. Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл
5. Ашигт малтмалын нөөцийг улсын бүртгэлд бүртгэсэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт
6. Нөөц бодсон геологийн дэвсгэр зураг
7. Олборлолтын журнал
8. Ашиглалтын үеийн геологи, маркшейдерийн бичиг баримт
9. Сар, улирлын гүйцэтгэлийн мэдээ
10. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн баримт
11. Төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын зардлыг нөхөн төлөх гэрээ, төлбөрийн баримт
12. Ажлын нарядын дэвтэр
13. Аваар устгах төлөвлөгөө
14. Тэсэлгээний ажил явуулах зөвшөөрөл
15. Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт
16. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтын бүртгэл
17. Өнгөрсөн жилийн уулын ажлын гүйцэтгэл тайлан
18. Ашиглаж дууссан блок хаасан тухай акт
19. Технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтын тайлан, баяжуулалтын алдагдал хаягдлыг өөрсдөө болон хяналтын байгууллагын тогтоосон тайлан, хяналтын байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
20. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн Менежментийн төлөвлөгөө
21. Байгаль орчин нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
22. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын 50%-ийг барьцаалсан баримт
23. Нөхөн сэргээлт хийсэн талбайг сум орон нутагт хүлээлгэн өгсөн акт
24. Газар ус ашиглах гэрээ болон төлбөр төлсөн тухай баримт
25. Уурхайн эдэлбэрийн шав тавиулсан тухай акт
26. Тухайн орон нутгаас ажиллаж буй хүмүүсийн судалгаа
27. Мэргэжлийн хяналтын байгууллагуудын улсын байцаагчаас урьд өмнө тавьсан албан шаардлага, албан шаардлагын хэрэгжилт
28. Тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө
29. Баяжуулах үйлдвэрийг бүртгүүлсэн баримт
30. Барилга, байгууламжийг хүлээж авсан техникийн комиссын акт, дүгнэлт